



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/94/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: Р.Цолмон
Утас: 261740 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК
Захирал Ж.Оюунцэцэг
Утас: 324338, 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 438/A0150127

Улаанбаатар хот

СИД Г-2023/94/НА-СТА-70A

Г Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бурэн эрхийн хүрээнд Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд санхүүгийн тайланд 37,023,384.00 /гучин долоон сая хорин гурван мянга гурван зуун наян дөрөв/ төгрөгийн авлага тусгаагүй, НӨАТ-ын 36,456,100.00 /гучин зургаан сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуу/ төгрөгийн өр төлбөр тайлагнаагүй, борлуулалтын 16,233,154.00 /арван зургаан сая хоёр зуун гучин гурван мянга нэг зуун тавин дөрөв/ төгрөгийн орлого дутуу тайлагнаж, нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлж, санхүүгийн тайланг буруу бэлтгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"; 5.1.4 "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримт бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"; 14.4.1 "аж ахуйн бүх ажил гүйлгээ"; 14.4.5 "бүх орлого"; 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ"; 20.2.5 "дансны өглөг, авлага, ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдаач этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

- Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, дотоод хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн захирал /Ц.Энхтүвшин/, ерөнхий нягтлан бодогч /Н.Уугаюнжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Атаяасад өөрчлөх
0023000000



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023

оны 03

дугаар сарын 21

№

439/А0150123

СНАГ-2023/94/ИА-СТА-708

Г Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Таваас дээш жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй 17,856,461.00 /арван долоон сая найман зуун тавин зургаан мянга дөрвөн зуун жаран нэгэн/ төгрөгийн авлагыг шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1."Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ", Няглан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага барагдуулах тухай өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /Ц.Энхтувшин/, ерөнхий няглан бодогч /Н.Ууганжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

*Ч.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД*

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardлага\2023\0315 SNAG-31 Docx

0001080952



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 01 № үүрэг № 440160150124

Улаанбаатар хот

СМГ-2023/94/НД-СТА-706

Г Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Налайхын Дулааны станц ТӨХК-д 1991-1999 онуудад гүйцэтгэх захирлаар ажиллаж, "Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" цол, тэмдгээр шагнуулсан хүнд Эрчим хүчний сайдын 2022 оны а/813 дугаар албан бичгээр өгсөн удирдамж, ТУЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоол, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны Хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.17 дахь заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/21 дүгээр тушаалаар 10,080,000.00 /арван сая наян мянга/ төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: ...15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэгтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-ыг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /Ц.Энхтувшин/, ерөнхий нягтлан бодогч /Н.Ууганжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙШЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

М. Оссаев

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

ЖОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингисийн татарын 1-р хороо, Бага тойрогийн 3-р хороо, 4 дүүзээр байр,
Утас 51-264230

© All rights reserved 2023.08.01 11:00:00

0301080960